

Компанийн засаглалын үнэлгээний асуулга

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц,

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь	
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	1. ТУЗ-ийн 2019 оны 05 сарын 15-ны өдөр 05/2019 тоот тогтоолоор баталсан ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тус бүрт нь тусгаж өгсөн. 2. 2023 оны 02-р сарын 11-ний өдрийн 05/2023 тоот ТУЗ-ийн тогтоолоор Комплайнсын хяналтын зааврыг батлуулж, ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ажил үүрэгт Комплайнсын ажилтны үүргийг хавсран хийж гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. Уг комплайнсын зааврыг tumenshuvuut.mn сайтад байршуулсан. ТУЗ-ийн гишүүн хөндлөгийн байгууллагаас сургалт, зөвлөгөө авахад зарцуулагдах зардал мөнгийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 5.8 дахь заалтанд тусгасан.		2	2	100.0
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгаж өгсөн. Уг журмын 3, 4-р зүйлд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх асуудлыг тус бүрт нь тусгасан. Мөн залгамж халааны бодлогыг ТУЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж хүргүүлсэн. ТУЗ-ийн гишүүний сонгон шаларуулалтай холбоотой журмыг шинэ ТУЗ-ийн анхны хурлаар хэлэлцүүлэх төлөвлөгөөтэй байна.		2	2	100.0
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i>	ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын жилийн ажлын гүйцэтгэлийг Нэр дэвшүүлэх хорооны зүгээс үнэлж дүгнэн ТУЗ-д тайлагнсан ба байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Бусад мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж зохицуулах байгууллагад хүргүүлж ажилладаг.		2	2	100.0
4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд дэргэдэх хороодын чиг үүрэг бүтэц бүрэлдэхүүн мэргэжил, ур чадварыг заасан байдаг.	ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүний хүйсийн зохицуулалтыг ТУЗ шийдвэрлэх боломжгүй ба хувьцаа эзэмшигчийн өөрийн сонголт юм. Гэхдээ цаашид Нэр дэвшүүлэх хорооны баримт бичигт тусгахыг зорьж ажиллана.	2	1	50.0
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдийг компанийн үйл ажиллагаатай танилцуулах, чиглүүлэх ажил хийгддэг. Өмнөх онуудад компанийн үйл ажиллагаатай танилцах ажлыг зохион байгуулж байсан. Шаардлагатай сургалт мэдээллээр хангаж ажилладаг		2	2	100.0

6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	ТУЗ-ийн НБД нь ТУЗ хурал болон дэргэдэх хороодын хурлын төлөвлөгөөг гаргаж, цаг тухайд нь хурал зохион байгуулах, тайлан мэдээ илгээх, бичиг хэрэг хөтлөх ажлыг хариуцан ажиллаж байгаа.		2	2	100.0
ДҮН				12	11	91.7
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ						
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ						
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 2.3 дахь заалт болон КТХуулийн 75.4 дэх заалтын дагуу ТУЗ-ийн 9 гишүүний 3 нь хараат бус гишүүн ба хараат бус гишүүд нь дэргэдэх хороодын даргын үүргийг гүйцэтгэнэ. Дэргэдэх хороодын 3-ны 2 нь хараат бус гишүүн байдаг.		2	2	100.0
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгасан. Аудитын хорооны дарга ТУЗ-ин хараат бус гишүүн байдаг. Хуралд зөвхөн Аудитын хорооны гишүүд болон ТУЗ нарийн бичиг оролцдог.		2	2	100.0
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	ТУЗ-ийн 2022 оны 11 сарын 23 өдрийн 13/2022 тоот тогтоол гарсан. Мөн 2023-2-11-ний өдрийн 03/2023 тоот тогтоолоор Цалин урамшууллын бодлогын бичиг баримтыг баталж, www.tumenshuvuut.mn сайтад байршуулсан.	Гүйцэтгэх удирдлагыг цалин урамшууллын хорооны гишүүнээс чөлөөлсөн шийдэр гарсан.	2	2	100.0
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгаж оруулсан. Хорооны дарга нь Хараат бус гишүүн байдаг. Залгамж халааны бодлогын бичиг баримтыг батлуулан хүргүүлсэн.		2	2	100.0
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	ТУЗ-ийн 2022 оны 11 сарын 23 өдрийн 11/2022 тоот тогтоолоор Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Ёс зүйн хороог байгуулан, хорооны ажиллах журмыг батлуулснаар тус компани нь албан ёсоор ТУЗ-ийн дэргэдэх 4 хороотойгоор үйл ажиллагаагаа явуулах болсон.		2	2	100.0
ДҮН				10	10	100.0
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ						
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана						

12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТУЗ-ийн 2019 оны 05-р сарын 15-ны 05/2019 тоот тогтоолоор баталсан ТШ ХК-ийн мэдээллийн үйл ажиллагааны журам баталсан. Журмын дагуу Зохицуулах хороо, Бирж болон компанийн цахим хуудаст мэдээлэл тайланг нээлттэй тавьдаг. Уг журмыг 2022.11.23-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан. өөрийн албан ёсны вэб хуудсанд байрлуулсан.		2	2	100.0
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Компанийн засаглалтай холбоотой дүрэм, журмууд нээлттэй байршуулдаг. 1. Компанийн дүрэм 2. "Түмэн шувуут" ХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам 3. Мэдээллийн үйл ажиллагааны журам 4. "Түмэн шувуут" ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам 5. "Түмэн шувуут" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам 6. "Түмэн шувуут" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Ёс зүйн хорооны ажиллах журам 7. Ёс зүйн дүрэм 8. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам 9. Комплайнсын хяналтын заавар 10. Ногдол ашгийн бодлого 11. Цалин урамшууллын бодлого 12. Залгамж халааны бодлого 13. Эрсдэлийн удирдлагын заавар 14. Компаний оролцогч талуудтай харилцах хамтран ажиллах бодлого		2	2	100.0
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Санхүүгийн тайлан болон санхүүгийн бус тайлан мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол холбогдох байгууллагууд болон компанийн www.tumenshuvuut.mn сайтад нээлттэй тавьдаг.		2	2	100.0
ДҮН				6	6	100.0
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО						
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана						

	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгахдаа эдгээр үүргийг оруулсан байгаа. Журмын дагуу Аудитын хороо үйл ажиллагаагаа явуулдаг. Хөндлөнгийн аудитын байгууллага жил бүр хяналт тавьж ажилладаг.		2	2	100.0
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хөндлөнгийн аудитаар ажилласан Онч аудит ХХК-ийн партнер Б.Анхтайван 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ХЭЭХ-д оролцож санхүүгийн тайланд аудит хийсэн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулж ажилласан.		2	2	100.0
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	"Түмэн шувуут" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос өгсөн чиглэлийн дагуу Гүйцэтгэх захирлын 2023 оны 01-р сарын 02-ны өдрийн Б/01 тоот тушаалаар Дотоод хяналтын ажилтан, А/01 тушаалаар Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам батласан бөгөөд журамд зааснаар дотоод хяналтын нэгжийг томилж ажиллаж байна. Дотоод хяналтыг зохион байгуулах журмыг tumenshuvuut.mn сайтад байршуулсан. Мөн Комплайнсын хяналтын зааврыг батлуулж ажилласан.		2	2	100.0
ДҮН				6	6	100.0
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА						
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина						
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Компанийн Эрсдэлийн удирдлагын зааврыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, гүйцэтгэх удирдлага өөрийн үйл ажиллагааны хүрээнд үйлдвэрийн байруудын галын аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн. Тус үнэлгээний үр дүнг хэлэлцэн учирч болзошгүй эрсдлийг арилгах зорилгоор төлөвлөгөө гарган ажиллаж байна.		2	2	100.0
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	ТУЗөвлөл нь эрсдэлийн удирдлагын зааврыг нь баталж, гүйцэтгэх удирдлагын баг эрсдэлийн төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.		2	2	100.0
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Компани нь байгаль орчны үнэлгээг жил бүр хийж тайлагнадаг. Ерөнхий үнэлгээг холбогдох байгууллагаар хийлгэж, олон нийтэд www.tumenshuvuut.mn сайтаар мэдээлдэг. Шувууны аж ахуйн үйл ажиллагаанд 2021 онд нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн. Гүйцэтгэгч байгууллага: Цагаан-уулын оргил ХХК		2	2	100.0

21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	ТУЗ-ийн 2023 оны 02 сарын 11 өдрийн 05/2023 тоот тогтоолоор Комплайнсын хяналтын зааврыг баталж, Комплайнсын ажилтан томилсон / tumenshuvuut.mn сайтад байршуулсан. \		2	2	100.0
ДҮН				8	8	100.0
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ						
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна						
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	ХЭХ-д ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээ, давтамжийг тогтмол хэлэлцүүлж баталдаг.		2	2	100.0
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	ТУЗ-ийн 2023 оны 02 сарын 11 өдрийн 03/2023 тоот тогтоолоор "Түмэн шувуут" ХК-ийн Цалин урамшууллын бодлогын баримт бичгийг баталж, tumenshuvuut.mn сайтад байршуулсан.		2	2	100.0
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд удирдах ажилтны цалин урамшууллыг тусгаж тайлагнадаг. Гүйцэтгэлийн шалгуурыг гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээнд тусгадаг.		2	2	100.0
ДҮН				6	6	100.0
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ						
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ						
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Компаний оролцогч талуудтай харилцах хамтран ажиллах бодлогыг баталж компаний цахим хуудсанд байршуулсан.		2	2	100.0
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Тайланд энэ тухай тусгадаг. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд, хувьцаа эзэмшигч, харилцагчидтай хамтран ажилласан талаар тайланд тусгаж оруулдаг.		2	2	100.0
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	https://www.facebook.com/tumenshuvuut болон http://tumenshuvuut.mn/ цахим хуудсуудад тогтмол мэдээлэл байршуулж ажилладаг.		2	2	100.0
	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт,	Ажилтнуудын санал хүсэлтийг www.timely.mn системээр дамжуулан авч эхэлсэн. Өмнө нь өргөдөл хэлбэрээр авдаг байсан.				100.0

28	гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Ажилтнуудыг чадавхжуулахад чиглэсэн сургалтуудыг гадны байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлдэг.		2	2	
ДҮН				8	8	100.0
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ						
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно						
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	www.tumenshuvuut.mn сайтаар дамжуулж нийтэд нээлттэй тавьсан.	Ёс зүйн дүрмийг батлан компаний нийт ажилтнуудад танилцуулсан.	2	2	100.0
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Ёс зүйн хорооны ажиллах журамд тусгаж оруулсан. Шүгэл үлээгчийн тогтолцооны талаар компанийн комплайнсын хяналтын зааварт тодорхой тусгаж оруулсан. Tumenshuvuut.mn сайтад уг дүрэм, зааврыг байршуулсан.		2	2	100.0
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Ёс зүйн дүрэмд тусгасан		2	2	100.0
ДҮН				6	6	100.0
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ						
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана						
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	www.tumenshuvuut.mn сайтад компанийн санхүүгийн мэдээлэл, бүтэц зохион байгуулалтыг ХЭ-дэд нээлттэй мэдээлдэг.		2	2	100.0
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хүрээнд Хувьцаатай өндөг хөтөлбөрийг зохион байгуулж, http://tumenshuvuut.mn/хувьцаатай-өндөг цахим сувгийг тогтмол ажиллуулж байна.		2	2	100.0
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	ХЭ-ийг хуралд оролцох, саналаа өгөх боломжийг биеэр болон онлайнаар, зайнаас оролцох системийн тусламжтайгаар бүрэн хангадаг. Энэ асуудлыг холбогдох журмын дагуу мөрдөж ажилладаг.		2	2	100.0
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Ийм асуудал одоогоор үүсээгүй байгаа.		2	2	100.0

36	<p>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</p>	<p>Уг журмыг 2019 оны 05-р сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар батласан. Өнөөдрийн байдлаар ийм хэлцэл хийгдээгүй болно. Уг журмыг tumenshuvuut.mn сайтад байршуулсан.</p>	2	2	100.0
ДҮН			10	10	100.0
НЭГДСЭН ДҮН			72	71	98.6
НЭГДСЭН ДҮН					

Засаглалын кодексын үнэлгээ:

90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй
70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх
50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн
49 болон түүнээс доош хувьтай бол мүү засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөрэрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай